



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 6/05

Ховд

Б.Бямбажавыг ажилд эгүүлэн томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалт, Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 221 дүгээр магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 415 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүүхийн шийдвэрийн дагуу Бадарчийн Бямбажавыг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалд эгүүлэн томилсугай.

2.Б.Бямбажавын ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөрт багтаан ажил хүлээлцүүлэхийг ажлын хэсэг /Д.Энхболд/-т даалгасугай.

3.Б.Бямбажавыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-10-5 дахь шатлал буюу 1088657 төгрөг /Нэг сая наян найман мянга зургаан зуун тавин долоон/-өөр цалинжуулж, хууль тогтоомжид заагдсан холбогдох нэмэгдлүүдийг сар бүр олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч /Ж.Болормаа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/05 Ch
02 00835

Аймгийн Засаг даргын
2020 оны 02 дугаар сарын 20 –ны өдрийн
Б/05 дугаар захирамжийн хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Энхболд- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Н.Ганзориг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн дарга

Б.Ганболд- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Ж.Болормаа- Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч

Д.Буянжаргал- Хүнс, хөдөө аж ахуйн газрын бичиг хэргийн
ажилтан, нярав

-оОо-